МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр Дугаар А/186 Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн болон сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Бор-өндөр, Дархан, Галшар, Баянхутаг, Хэрлэн, Өмнөдэлгэр сумдад инженерийн хийцтэй худаг шинээр барих, Бор-өндөр, Галшар суманд Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Б.Саранцэцэг	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга
	Ч.Мөнх-Эрдэнэ	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\захирамж.2022